



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016-2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 443.8 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаранд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн ажлын хүрээнд сүүлийн жилүүдэд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, татвар төлөөгүй байгаа тээврийн хэрэгслийн судалгааг шинэчлэн гаргаж, бүртгэлийн сангаас хасах,

2.3. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.4. Байгууллагын жил, жилийн санхүү, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн орлого, зарлагын төлөвлөлтийг хийхдээ санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ, эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамик судалгаа, хүрсэн бодит үр дүнд тулгуурласан төсвийн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;

2.5. Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчим, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2018 оны 8 дугаар тогтоолыг тус тус мөрдөж ажиллах;


2.6. Гадаад болон дотоод албан томилолтын хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, эрх бүхий байгууллагын удирдамж, томилолтгүй ажилладаг, Зам тээврийн яамны албан тушаалтнуудын гадаад албан томилолтын зардлыг байгууллагаас хариуцдаг явдлыг зогссох;

2.7. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж, засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан санхүүгийн баримтаар зарлагын гүйлгээ хийж ажиллах;

2.8. Тээвэр төлөвлөлт, нэгдсэн зохицуулалтыг үр ашигтай, шуурхай зохион байгуулж, ухаалаг тээврийн системийг нэвтрүүлэх ажлыг тууштай хэрэгжүүлж, тээвэрлэлтийн нэгдсэн системийг шинэчилж боловсронгуй болгох,

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 9 дугаар сарын 5-ны өдрийн 38 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт



№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн мян.төгрөг	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг хэрэгслэл, бараа материал	Захирал П. Дэлгэрнаран Ерөнхий ня-бо З.Оюунсүрэн	41 378,00	Бараа материал бэлтгэх журам боловсруулж, мөрдөж ажиллах
2	Хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулаагүй ажил үйлчилгээ	Захирал П. Дэлгэрнаран Ерөнхий ня-бо З.Оюунсүрэн	144 679,70	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдана авах тухай хуулийг мөрдөж ажиллах
3	Даатгалын компаниудад сонгон шалгаруулалт явуулалгүй төлсөн даатгалын хураамж		41 500,00	
	Сонгон шалгаруулалт хийлгүй шууд худалдан авсан		103 179,70	
4	Байгууллагын үйл ажиллагаатай холбоогүй үргүй зардал	Захирал П. Дэлгэрнаран Ерөнхий ня-бо З.Оюунсүрэн	125 527,25	Монгол Улсын "Төсвийн тухай хууль"-ийг мөрдөж ажиллах
5	Дотоод албан томилолтын журам зөрчсөн	Захирал П. Дэлгэрнаран Ерөнхий ня-бо З.Оюунсүрэн	34 100,00	Албан томилолтын журмыг мөрдөж ажиллах
	Гадаад албан томилолтын журам зөрчсөн		77 100,00	
6	Журам зөрчин олгосон цалин, урамшуулал	Захирал П. Дэлгэрнаран Ерөнхий ня-бо З.Оюунсүрэн	21 000,00	Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль"-ийн заалтыг хэрэгжүүлж ажиллах
	Дүн		443 784,95	